



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/287

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Б.Батсүх (ГЮ40091037)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 16 дугаар гудамж 1612 тоотод байршилтай 6308002809 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 600 м2 газрын газар эзэмших эрхийг Б.Баттулга (ГЮ76031319)-д, С.Ганцэцэг (ГЖ84052802)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 4 дүгээр гудамж 430 тоотод байршилтай 6308005548 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 592 м2 газрын газар эзэмших эрхийг Б.Баттулга (ГЮ76031319)-д, Г.Оюунтуяа (ГЮ72120301)-гийн Булган сум 6 дугаар баг Залуус 17 дугаар гудамж 1702 тоотод байршилтай 6308002815 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 849 м2 газрын газар эзэмших эрхийг Б.Батзориг (ГЮ96110251)-т тус тус шилжүүлсүгэй.

2. Б.Баттулга, Б.Батзориг нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Булган сумын Засаг даргын 2010 оны 76 дугаар захирамжийн Б.Батсүх, аймгийн Засаг даргын 2017 оны А/436 дугаар захирамжийн С.Ганцэцэг, 2019 оны А/107 дугаар захирамжийн Г.Оюунтуяа нартай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

